

2015 оны 3 дугаар сарын 3-ны өдөр

№53

Улаанбаатар хот

"АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС" ХУВЬЦААТ КОМПАНИ
(цаашид **Компани** гэх)-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (цаашид **ТУЗ** гэх)-ИЙН ТОГТООЛ

Аудит болон үнэлгээний компаниудыг сонгох тухай

Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох үнэлгээний компани, түүнчлэн аудитын дүгнэлт гаргах компанийг тус тус сонгох тухай асуудлаар Компанийн тухай хуулийн 80.4 болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 11.7-д заасны дагуу Компанийн ТУЗ-д өгөх мэдэгдэл болон эчнээ санал хураалтын хуудсыг ТУЗ-ийн бүх гишүүдэд 2015 оны 2 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлсэн;

Дээрх асуудлаар санал өгөх эрх бүхий 9 гишүүнээс 8 гишүүний саналаар нийт 88,8 хувийн саналаар "Фискал Аудит" ХХКомпанийг аудит хийлгэхээр, нийт 88,8 хувийн саналаар "Лэндс" ХХКомпанийг үнэлгээ хийлгэхээр тус тус сонгосон.

Тиймээс Компанийн тухай хуулийн 56 болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн эчнээ саналын хуудсаар ирүүлсэн саналуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргах компаниар "Фискал Аудит" ХХК сонгосугай;
2. Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох үнэлгээний компаниар "Лэндс" ХХК сонгосугай ;
3. Дээрх 2 компанитай гэрээ байгуулж гарын үсэг зурж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал Дангаасүрэнгийн Галбадрахад үүрэг болгосугай.



Ли Майкл Кашелл

"Азиа Пасифик Пропертис" хувьцаат компанийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн Дарга